

“СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ КОРПОРАЦ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага:

Хараат бус гишүүнд нэр дэвшигч нь Компанийн тухай хуулийн 79.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Банк, санхүү, эдийн засаг, нягтлан, хууль эрх зүйн чиглэлийн аль нэгээр дээд боловсролтой, Хот төлөвлөлт, инженерчлэл, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
2. Компанийн нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын /зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч, болон ихээхэн хувьцаа эзэмшигчид/ ашиг сонирхлыг төлөөлдөггүй байхаас гадна бизнесийн аливаа холбоогүй байх;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй нэгдмэл сонирхолтой биш, тэдэнтэй садан төрлийн холбоогүй байх;
4. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй, ял шийтгэлгүй, ёс зүйн болон ажил хэргийн нэр хүнд нь харшлахгүй байх;
5. Өмнө нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал байгаагүй;
6. Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь НИТХ-ын төлөөлөгч биш, Нийслэлийн ямар нэг байгууллагад эрх бүхий албан тушаал хашдаггүй;
7. Компанийн ТУЗ-ийн бусад гишүүн, Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
8. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байх. Компанийн засаглалаар мэргэшсэн байх.

Бүрдүүлэх материал:

1. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт
2. Анкет (төрийн албан хаагчийн анкетыг бүрэн бөглөх, 4х6 хэмжээтэй цээж зураг заавал наасан байх);
3. Ажил байдлын тодорхойлолт (ажил эрхэлдэг иргэн байгууллагаасаа тодорхойлолт авах, ажил эрхэлдэггүй иргэн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл);
4. Боловсролын диплом, үнэмлэх, бусад сургалт, семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын хуулбар;
5. Иргэний үнэмлэхийн хуулбар;
6. Компанийн засаглалын гэрчилгээний хуулбар;
7. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгүүлж байсан эсэх лавлагаа;
8. Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа, газар:

Сонгон шалгаруулалтад орох иргэний материалыг **2025 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн 17:00** цаг хүртэл “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн оффисын байр буюу Чингэлтэй дүүрэг, MN таур 19 давхар 1910 тоот өрөөнд хүлээн авна.

Утас: 7700-2078

Анхаарах зүйлс:

1. Материалыг битүүмжилсэн байх ба дугтуйн гадна талд сонгон шалгаруулалтад оролцогч иргэний оршин суух хаяг, холбоо барих утасны дугаарыг тус тус гаргацтай бичнэ.
2. Материалыг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй болно.
3. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
4. Материалын бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
5. Сонгон шалгаруулалтын шаардлага хангасан иргэнтэй Нэр дэвшүүлэх хорооноос холбоо барина.

**“СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ КОРПОРАЦ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО**